



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/536

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үенч, Ховд сумдын зорилтот бүлгийн эхчүүд, хүүхдүүдэд нарийн мэргэжлийн эмч нарын оролцоотой эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийх, шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах замын зардал, унааны хөлс, эмч нарын томилолтын зардалд 18 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 18 000 000 төгрөг /арван найман сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.13 дахь заалтын “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ” төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ